МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр Дугаар А/126 Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож,
захиалагчийн төлөөлөгч томилж,
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 48 дугаар зүйлийн 48.2.6, 46.2.7, 48.2.9, Засгийн газрын 2023 оны "Журам батлах тухай" 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны "Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай" А/258 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, мод тарьж ногоон суварга босгоё аяны хүрээнд Мөрөн сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 100.0 сая төгрөгийн тендерт гүйцэтгэгч шалгараагүй ажил дээр 2023 оны тендерийн хэмнэлтээс 55.0 саяыг нэмэгдүүлж ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавих туулах чадвар сайтай авто машин худалдан авах ХӨАХААГ/20240102141 дугаартай тендерт 154,000.000 (Нэг зуун тавин дөрвөн сая) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Кибер жаал" ХХК -ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2."Кибер жаал" ХХК -тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий "Захиалагчийн төлөөлөгч"-өөр аймгийн Аймгийн Байгаль Орчин Аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга (Х.Хадбаатар)-г томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:
Х.Хадбаатар (Аймгийн Байгаль Орчин Аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга)

Ажлын хэсгийн гишүүд:
Б.Цэнддэлгэр (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)
Ш.Дарьжав ("Кибер жаал" ХХК-ийн захирал)
Ё.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

6712010383

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:
Д.Нямдаваа (Аймгийн Байгаль Орчин Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

3.Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, мод тарьж ногоон суварга босгоё аяны хүрээнд Мөрөн сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 100.0 сая төгрөгийн тендерт гүйцэтгэгч шалгараагүй ажил дээр 2023 оны тендерийн хэмнэлтээс 55.0 саяыг нэмэгдүүлж ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавих туулах чадвар сайтай авто машин худалдан авах худалдан авах гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Х.Хадбаатар)-д, захиалагч, тендерт оролцогчийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024